

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 23/001

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн  
тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Мандал Даатгал ХК-ийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, тус тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2023 оны 04 сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Мандал Даатгал ХК-ийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Хавсралт №1 ёсоор баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА



Ө.ГАНЗОРИГ

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 23/002

Улаанбаатар хот

Компанийн ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны  
зардлын төсөв батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.13 дэх хэсэг, Мандал Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2021 оны 04 сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын №21/003 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан Мандал Даатгал ХК-ийн дүрмийн 7-р зүйлийн 7.8.7 дэх хэсэг, 2023 оны 04 сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны зардлын төсвийг дараах бүтэцтэйгээр баталсугай:

Д/д	Зардлын төсөв	Нийт зардал /төгрөг/
1	ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарын цалин, урамшуулал	154,000,000
2	Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн хурал	20,000,000
3	Бичиг хэрэг болон бусад	6,000,000
	Дүн	180,000,000

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА



Ө.ГАНЗОРИГ